

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС  
СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ АЛБА

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЕРӨНХИЙ САЙДЫГ  
ТОМИЛОХ, ЗАСГИЙН ГАЗРЫГ БҮРДҮҮЛЭХ ПРОЦЕДУР, ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ,  
ЧӨЛӨӨЛӨХ, ОГЦРУУЛАХ БОЛОН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
БҮТЦИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

---

(Харьцуулсан судалгаа)  
СТ-17/218

ХЯНАСАН: Д.Халиун  
СУДЛААЧИД: Ц.Болормаа  
Г.Билгээ  
Д.Жигваагүнсэл  
Д.Халиун

УЛААНБААТАР  
2017 он

**АГУУЛГА**

## Удиртгал

- Нэг. Үндсэн хуульд улсын дээд шүүхийн шүүгч, бусад шүүхийн шүүгч, бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчийг томилох, чөлөөлөх, огцруулах талаар
- Хоёр. Шүүхийн шүүгчээр томилогдох насны дээд, доод хязгаар шүүгчийг томилохдоо хугацаа заадаг эсэх, бүх насаар нь томилдог эсэх, шүүгчээр анх томилоход туршилтын хугацаа хэрэглэдэг эсэх талаар
- Гурав. Үндсэн хуульд шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаар
- Дөрөв. Үндсэн хууль дахь ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг бүрдүүлэх асуудлаар

Ашигласан материал

## УДИРТГАЛ

УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангийн захиалгаар “Гадаадын зарим орны Үндсэн хууль дахь Ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг бүрдүүлэх процедур, шүүгчийг томилох, чөлөөлөх, огцруулах болон шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтцийн талаарх зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэв.

Шүүгчийг томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалт, шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтцийн Үндсэн хуулийн зохицуулалтыг 15 улсын хүрээнд, Ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг бүрдүүлэх процедурыг захиалагчийн хүсэлтэд дурдсан 6 улсын хүрээнд тус тус судалсан болно.

**Нэг. Үндсэн хуульд улсын дээд шүүхийн шүүгч, бусад шүүхийн шүүгч, бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчийг томилох, чөлөөлөх, огцруулах талаар**

Томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалт			
Улсын нэр	Ерөнхийлөгч/ Эзэн хаан	Парламент	Засгийн газар/ Шүүхийн зөвлөл
1	Израиль	Шүүхийн Сонгуулийн Хорооны сонгосны дагуу Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.	-
2	Испани	Эзэн хаан Дээд шүүхийн Ерөнхийлөгчийг томилно.	

3	Итали			<p>өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар томилно.</p> <p>Кассацийн зөвлөхүүд нь Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөлийн саналыг үндэслэн мэрит зарчмаар шүүгчийг томилно.</p> <p>Шүүгчийг албан тушаалаас чөлөөлж болохгүй. Дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгчийг албан тушаалаас нь огцруулах болон түдгэлзүүлж болохгүй:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Бусад шүүхэд томилогдсон;</li> <li>-Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөлийн шийдвэрээр;</li> <li>-Шүүх эрх мэдлийн байгууллагуудын холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр; эсхүл</li> <li>-Шүүгчийн өөрийн хүсэлтээр.</li> </ul> <p>Хууль зүйн сайд сахилгын арга хэмжээ авах бүрэн эрхтэй.</p>
4	Киргиз	<p><b>-Дээд шүүхийн шүүгчдийг</b> 1/Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн санал болгосноор <b>сонгуулахын тулд</b>,</p> <p>2/Шүүхийн зөвлөлийн санал болгосноор албан үүргээс <b>чөлөөлөхийн тулд</b> тус тус <b>Парламентад</b> танилцуулах.</p> <p><b>-Орон нутгийн шүүхийн шүүгчдийг</b> 1/Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн санал болгосноор <b>томилох</b>, 2/ Шүүхийн зөвлөлийн санал болгосноор <b>чөлөөлөх</b>.</p>	Ерөнхийлөгчийн танилцуулснаар <b>Дээд шүүхийн шүүгчдийг сонгох, чөлөөлөх.</b>	
5	Нидерланд	Эзэн хаан Шүүхийн шүүгчдийг томилно.		
6	Словак	<p><b>Дээд шүүхийн ерөнхий шүүгч</b> - Ерөнхийлөгч</p> <p><b>Бүх шатны шүүгч</b> – Шүүхийн зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч</p>	-	-

7	Словени	-	Бүх шатны шүүгч - Шүүгчийн зөвлөлийн санал болгосноор Парламент	-
8	Унгар	Мэргэжлийн шүүгч	-	-
9	Финланд	Байнгын шүүгч	-	-
10	Хорват	-	Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн Парламент	Үндэсний шүүхийн зөвлөл
11	Чех	Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, дэд шүүгч Бүх шатны шүүгч	-	-
12	Швед	-	-	Байнгын шүүгч
13	Швейцар	-	Дээд шүүхийн шүүгч	-
14	Эстони	Бусад шүүгч – Дээд шүүх санал болгосноор Ерөнхийлөгч	Дээд шүүхийн ерөнхий шүүгч – Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент Дээд шүүхийн шүүгч- Дээд шүүхийн ерөнхий шүүгч санал болгосноор Парламент	-
15	Япон	Дээд шүүхийн ерөнхий шүүгч – Засгийн газрын өргөн мэдүүлснээр Эзэн хаан	-	Бүх шатны шүүгч

**Хоёр. Шүүхийн шүүгчээр томилогдох насны дээд, доод хязгаар шүүгчийг томилохдоо хугацаа заадаг эсэх, бүх насаар нь томилдог эсэх, шүүгчээр анх томилоход туршилтын хугацаа хэрэглэдэг эсэх талаар**

Улсын нэр		Шүүгчийн томилоход насны дээд, доод хязгаар, бүх насаар нь томилдог эсэх				
		Доод	Дээд	Томилох хугацаа	Бүх насаар	Туршилтын хугацаа заадаг эсэх
1	Израиль	-	-	-	Бүх насаар	-
2	Испани	-	-	-	-	-
3	Итали	-	-	-	Бүх насаар	-
4	Киргиз	-Дээд шүүхийн шүүгч: <b>40 нас</b> -Орон нутгийн шүүхийн шүүгч: <b>30 нас</b>	-Дээд шүүхийн шүүгч: <b>70 нас</b> -Орон нутгийн шүүхийн шүүгч: <b>65 нас</b>	Насны <b>дээд хязгаар</b> хүрэх хүртэл	-	Орон нутгийн шүүхийн шүүгчдийг <b>эхний удаа 5 жилийн хугацаатай</b> томилно
5	Нидерланд	-	-	-	Бүх насаар	-

6	<b>Словак</b>	30 нас хүрсэн	65 нас	Дээд шүүхийн ерөнхий шүүгч, дэд шүүгч - 5 жил	Насны хязгааргүй	-
7	<b>Словени</b>	-	/хуулиар тогтооно/	-	Бүх насаар	-
8	<b>Унгар</b>	30 нас хүрсэн	Тэтгэврийн нас	-	-	-
9	<b>Финланд</b>	-	Тэтгэврийн нас	-	-	-
10	<b>Хорват</b>	-	70 нас	Дээд шүүхийн ерөнхий шүүгч - 4 жил	Бүх насаар	-
11	<b>Чех</b>	-	-	-	Н а с н ы хязгааргүй	-
12	<b>Швед</b>	-	Тэтгэврийн нас	-	-	-
13	<b>Швейцар</b>	Холбооны дээд шүүхийн шүүгч - 18 нас хүрсэн	-	Холбооны дээд шүүхийн шүүгч - 6 жил	-	-
14	<b>Эстони</b>	-	-	-	Бүх насаар	-
15	<b>Япон</b>	-	-	Дээд шүүхийн шүүгч - 10 жил	-	-

Улсын нэр

Шүүхийн шүүгчээр томилогдох насны дээд, доод хязгаар шүүгчийг томилохдоо хугацаа заадаг эсэх, бүх насаар нь томилдог эсэх, шүүгчээр анх томилоход туршилтын хугацаа хэрэглэдэг эсэх зохицуулалт

1	Израиль	<p style="text-align: center;"><b>ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СУУРЬ ХУУЛЬ (1964)</b></p> <p><b>11. Бүрэн эрх, чиг үүрэг (amendments 3 and 5)</b>  а. Улсын Ерөнхийлөгч нь:  б. Шүүгчид болон бусад албан хаагчдыг хуулийн дагуу албан тушаалд нь томилох, албан тушаалаас нь чөлөөлөх.</p> <p style="text-align: center;"><b>ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН СУУРЬ ХУУЛЬ (1984)</b></p> <p><b>4. Шүүгчдийг томилох</b>  а. Шүүгчийг хуульд заасан журмын дагуу Шүүхийн сонгуулийн хорооны сонгосноор Улсын Ерөнхийлөгч томилно.</p> <p><b>5. Үндэс угсаа</b>  Зөвхөн Израиль үндэстнийг шүүгчээр томилно.</p> <p><b>7. Албан тушаал хаших хугацаа (AMENDMENT 2)</b>  Шүүгчийн албаны бүрэн эрх шүүгчийн тангараг өргөснөөр эхэлж, зөвхөн дараах тохиолдолд дуусгавар болно:  1. тэтгэвэрт гарсан;  2. огцорсон;  3. Кнессетээс өөр албан тушаалд (<i>Кнессетийн суурь хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу шүүгч парламентад нэр дэвшихийг хориглоно</i>) сонгогдсон эсхүл томилогдсон;  4. Шүүгчийн сонгуулийн хорооны даргын шийдвэр, Израилийн Шүүхийн Омбудсмэн, эсхүл Дээд шүүхийн Ерөнхийлөгчийн шийдвэр болон долоон гишүүнээс багагүй олонхиор баталсан шийдвэрийн дагуу; эсхүл  5. Сахилгын шүүхийн шийдвэрийн дагуу албан тушаал хаших хугацаа дуусгавар болно.</p> <p><b>8. Чөлөөлөгдсөн шүүгч</b>  Хуульд заасан нөхцөл журмын дагуу тэтгэвэрт гарсан үндэслэлээр чөлөөлөгдсөн шүүгчийг шүүгчийн албан тушаалд томилж болно.</p> <p style="text-align: center;"><b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ</b></p> <p><b>23. Хуульд заасан журмаар зохицуулах</b>  Дор дурдсан асуудлыг хуулиар зохицуулна:  1. Шүүгчийн сонгуулийн хорооны гишүүд, бүрэн эрхийн хугацаа, сонгуулийн хэлбэр;  2. бүх шүүхийн шүүгчдэд тавигдах шаардлага;  3. Дээд шүүхийн Ерөнхийлөгч (Ерөнхий шүүгч), дэд ерөнхийлөгч, Тойргийн шүүх болон Магистратийн шүүхийн Ерөнхийлөгч (Ерөнхий шүүгч) болон дэд ерөнхийлөгчийг томилох журам;  4. шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэл, журам;  5. өөр шүүхийн үүргийг түр орлох шүүгчийг томилох журам, шүүгчийг түр болон бүр шилжүүлэх;  6. шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, түдгэлзүүлснийг хянан үзэх үйл ажиллагаа;  7. шүүгч дангаар болон гурав, эсхүл түүнээс дээш бүрэлдэхүүнтэй шүүх харъяаллын асуудал;  8. шүүгчид дангаар эсхүл шүүгчийн бүрэлдэхүүнд хэрэг хуваарилах.</p>
2	Испани	<p><b>117-р хэсэг.</b>  2. Шүүгчид, магистратыг хуульд заасан үндэслэл, баталгааны дагуу огцруулах, түр түдгэлзүүлэх, шилжүүлэх, эсхүл тэтгэвэрт гаргана.</p>

3	Итали	<p><b>87 дугаар зүйл</b>  Ерөнхийлөгчийн бүрэн эрх:  -хуульд заасан тохиолдолд төрийн албан хаагчдыг томилох</p> <p><b>106 дугаар зүйл</b>  Шүүгчдийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар томилно.  Кассацийн зөвлөхүүд нь хуульд заасан журмын дагуу хуулийн сургуулийн профессорууд, 15 жилийн ажлын туршлагатай хуульчид болон дээд шатны шүүхэд бүртгэлтэй мэргэшсэн өмгөөлөгчдийн албан ёсны бүртгэлээс Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөлийн саналыг үндэслэн мэрит зарчмаар шүүгчийг томилно.</p> <p><b>107 дугаар зүйл</b>  Шүүгчийг албан тушаалаас чөлөөлж болохгүй. Дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгчийг албан тушаалаас нь огцруулах болон түдгэлзүүлж болохгүй:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бусад шүүхэд томилогдсон;</li> <li>- Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөлийн шийдвэрээр;</li> <li>- Шүүх эрх мэдлийн байгууллагуудын холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр; эсхүл</li> <li>- Шүүгчийн өөрийн хүсэлтээр.</li> </ul> <p>Хууль зүйн сайд сахилгын арга хэмжээ авах бүрэн эрхтэй.  Шүүгчид зөвхөн өөр өөрийн чиг үүргээр ялгагдана.  Улсын прокурор нь Шүүх эрх мэдлийн зохион байгуулалтын холбогдох зүйлд заасан прокурорын баталгаагаар хангагдана.</p>
---	-------	--



4	Киргиз	<p><b>64-р зүйл.</b> 3.Ерөнхийлөгч: 1) Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн санал болгосноор Парламентад Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг сонгуулахаар танилцуулах; 2) Шүүхийн зөвлөлийн санал болгосноор Дээд шүүхийн шүүгчдийг албан үүргээс чөлөөлөхийн тулд Парламентад танилцуулах; 3) Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн санал болгосноор орон нутгийн шүүхийн шүүгчдийг томилох; 4) Шүүхийн зөвлөлийн санал болгосноор орон нутгийн шүүхийн шүүгчдийг чөлөөлөх</p> <p><b>64-р зүйл.</b> 4.Парламент: 1) Ерөнхийлөгчийн танилцуулснаар Дээд шүүхийн шүүгчдийг сонгох; үндсэн хуулийн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн танилцуулснаар Дээд шүүхийн шүүгчдийг албан үүргээс чөлөөлөх;</p> <p><b>94-р зүйл.</b> 5.Дээд шүүхийн шүүгч нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, 40-өөс дээш, 70-аас доош насны БНКУ-ын иргэн байна. 6.Дээд шүүхийн шүүгчдийг насны дээд хязгаар хүрэхээс өмнө сонгогдоно. 7.Дээд шүүхийн шүүгчид өөрийн гишүүдээс Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, түүний орлогчийг 3 жилийн хугацаатай сонгоно. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий шүүгчийн орлогчийг 2 удаа дараалан сонгохгүй. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон түүний орлогчийг сонгох, чөлөөлөх журмыг хуулиар тогтооно. 8.Орон нутгийн шүүхийн шүүгч нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, 30-аас дээш, 65-аас доош насны БНКУ-ын иргэн байна. Орон нутгийн шүүхийн шүүгчдийг Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч <b>эхний</b> удаа 5 жилийн хугацаатай, дараагийн удаа насны дээд хязгаар хүрэх хүртэл томилно. Орон нутгийн шүүхийн шүүгчдийг танилцуулах, томилох журмыг үндсэн хуулийн хуулиар тодорхойлно. Орон нутгийн шүүхийн шүүгчдийн хурлаар өөрийн гишүүдээс Шүүхийн дарга, орлогч даргыг 3 жилийн хугацаатай сонгоно. Орон нутгийн шүүхийн дарга, орлогч даргыг нэг шүүхэд 2 удаа дараалан сонгохгүй. 9.БНКУ-ын шүүгчийн эрх зүйн байдлыг үндсэн хуулийн хуулиар тогтоох ба уг хуульд шүүгчид нэр дэвшигчдэд тавигдах нэмэлт шаардлагыг тогтоож болно.</p> <p><b>95-р зүйл.</b> 1.БНКУ-ын бүх шатны шүүхийн шүүгчид албан үүргээ хэрэгжүүлэх ба өв тэгш ёс зүйтэй байгаа тохиолдолд бүрэн эрхээ хэвээр хадгална. Шүүгчдийн өв тэгш ёс зүйд тавигдах шаардлага зөрчигдсөн бол үндсэн хуулийн хуулиар тогтоосон журмын дагуу хариуцлагад татах үндэслэл болно. 2.Дээд шүүхийн шүүгчдийг Шүүхийн зөвлөлийн санал болгосны дагуу Ерөнхийлөгч Парламентад танилцуулснаар Парламентын нийт гишүүдийн 2/3-ний саналаар хугацаанаас нь өмнө албан үүргээс нь чөлөөлнө. 3.Шүүгчийг нас барсан, эсхүл сураггүй алга болсон гэж зарласан, эрх зүйн чадамжгүй болсонд тооцсон, иргэншлээ алдсан, иргэншлээс гарсан, эсхүл бусад улсын иргэншилтэй болсон тохиолдолд шүүгчийг сонгосон, эсвэл томилсон эрх бүхий байгууллага нь үндсэн хуулийн хуулийн дагуу үндэслэл үүссэн өдрөөс эхлэн түүний бүрэн эрхийг дуусгавар болгоно. 4.Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөл нь Орон нутгийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг сонгох болон томилсон, эсхүл шилжүүлсэн талаар мэдэгдэх үүргийг үндсэн хуулийн хуулиар тогтоосон журмын дагуу хэрэгжүүлнэ. 5.Шүүхийн зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч нь Орон нутгийн шүүхийн шүүгчдийг албан үүргээс нь үндсэн хуулийн хуулиар тогтоосон журмын дагуу огцруулж, чөлөөлнө.</p>
---	--------	---

5	<b>Нидерланд</b>	<p><b>117-р зүйл.</b>  1. Шүүхийн шүүгчдийг Эзэн хаан бүх насаар нь томилно.  2. Шүүгчид огцорсон, эсхүл хуулиар тогтоосон насны хязгаарт хүрсэн тохиолдолд албан үүргээ хэрэгжүүлэхгүй.  3. Албан үүргээ хэрэгжүүлэхгүй болсон шүүгчийг хуульд заасны дагуу шүүх чөлөөлөх, эсхүл огцруулна.  4. Шүүгчийн эрх зүйн байдлыг хуулиар зохицуулна.</p>
6	<b>Словак</b>	<p>86-р зүйл. Словак Улсын Үндэсний зөвлөл /Парламент/ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.  102-р зүйл. Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.  Шүүгч, Дээд шүүхийн ерөнхий шүүгч, дэд шүүгч, Ерөнхий прокурор болон Шүүхийн зөвлөлийн 3 гишүүнийг тус тус томилно.  141а-р зүйл.  5с. Шүүхийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  Ерөнхийлөгчид шүүгчээр томилогдох нэр дэвшигчдийн нэрсийг оруулах, шүүгчээс огцруулах нэрсийг оруулах.  145-р зүйл.  1. БНСловак Улсын Ерөнхийлөгч нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор <b>шүүгчдийг томилж, чөлөөлнө.</b> Шүүгчийг хугацааны хязгааргүй томилно.  2. Үндэсний зөвлөл /Парламентын/ гишүүнээр сонгогдох шаардлагыг хангасан, <b>30 нас хүрсэн</b>, хууль зүйн боловсролтой, шүүгчид тавигдах шаардлагыг хангасан, шүүгчийн албыг дүрэм журмын дагуу явуулахыг баталсан Словак Улсын иргэн бүр шүүгчээр томилогдох эрхтэй байна. Шүүгчээр томилох, дэвшүүлэх нөхцөл, мөн шүүгчийн халдашгүй байдлыг хуулиар тогтооно.  3. <b>БНУлсын Ерөнхийлөгч Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, дэд шүүгчийг Дээд шүүхийн шүүгчдийн дотроос Шүүхийн зөвлөлийн санал болгосноор 5 жилийн хугацаагаар томилно.</b> Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн нэг удаа улируулан томилж болно.  147-р зүйл. <b>БНУлсын Ерөнхийлөгч шүүгчийг</b> Шүүхийн зөвлөлийн санал болгосноор гэмт хэрэг санаатайгаар үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, шүүхийн шийдвэрийн дагуу хорих ял оноогоогүй, эсхүл ёс зүйн сенатаас шүүгчийн албатай харшлах үйл ажиллагаа явуулсан, эсхүл Үндэсний зөвлөл /Парламент/-д сонгогдох эрх нь хасагдсан тохиолдолд огцруулна.  2. <b>БНУлсын Ерөнхийлөгч</b> Шүүхийн зөвлөлийн саналыг үндэслэн <b>шүүгчийг дараах тохиолдолд чөлөөлнө.</b> Үүнд:  А. Эрүүл мэндийн шалтгаанаар 1 жилээс илүү хугацаагаар ажил үүргээ биелүүлэх боломжгүй,  Б. <b>65 на хүрсэн.</b></p>
7	<b>Словени</b>	<p>129-р зүйл. <b>Шүүгчийг бүх насаар нь томилно.</b> Шүүгчээр томилогдох насны хязгаар болон бусад шаардлагыг хуулиар тогтооно.  Шүүгчийн тэтгэвэрт гарах насыг хуулиар тогтооно.  130-р зүйл. <b>Шүүгч нарыг Шүүхийн зөвлөлийн санал болгосноор Парламент томилно.</b>  132-р зүйл. Шүүгчийг огцруулах, чөлөөлөх үндэслэл.  Шүүгчийг хуульд заасан үндэслэлийн дагуу огцруулж, чөлөөлнө.  <b>Шүүгч ажил үүргээ гүйцэтгэхдээ Үндсэн хууль, эсхүл хуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд Шүүхийн зөвлөлийн санал болгосноор Парламент огцруулна.</b>  Эцсийн шийдвэрээр шүүгч нь санаатайгаар шүүгчийн эрх мэдлээ ашиглан гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол Парламент түүнийг огцруулна.</p>
8	<b>Унгар</b>	<p>Ерөнхийлөгч  9-р зүйл.  Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  к. Мэргэжлийн шүүгч болон Төсвийн зөвлөлийн ерөнхийлөгчийг томилно.  25 -р зүйл.  2. <b>Мэргэжлийн шүүгчийг /Professional judge/ Ерөнхийлөгч хуульд заасны дагуу томилно.</b>  26-р зүйл.  2. <b>Мэргэжлийн шүүгчийн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч томилно.</b>  Шүүгчээр зөвхөн <b>30 нас хүрсэн</b> иргэнийг томилно. Дээд шүүх /Курия/-ийн ерөнхий шүүгч болон Үндэсний шүүхийн зөвлөлийн даргаас бусад шүүгчийн бүрэн эрх тэтгэврийн нас хүрснээр дуусгавар болно.</p>

9	<b>Финланд</b>	<p>100-дугаар зүйл. Дээд шүүх болон Захиргааны дээд шүүхийн бүтэц Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүх нь <b>Дарга болон шаардлагатай тооны</b> шүүгчдээс бүрдэнэ. Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүхийн хуульд өөрөөр заагаагүй бол шийдвэр гаргах ирц 5 гишүүн байна. 102-р зүйл. Шүүгчийн томилгоо Байнгын шүүгчийг <b>Ерөнхийлөгч хуульд заасан журмын дагуу томилно. Бусад шүүхийн шүүгчдийг хуульд заасан журмын дагуу томилно.</b> 103-р зүйл. Шүүгчдийг зөвхөн шүүхийн шийдвэрээр огцруулна. Түүнчлэн, шүүхийн албаны бүтцийн өөрчлөлтөөс бусад тохиолдолд, шүүгчийг өөр албан өөрийнх нь зөвшөөрөлгүй шилжүүлэхийг хориглоно. Тодорхой насанд тэтгэвэрт гарах, эсхүл хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд ажлаас чөлөөлөх журмыг хуулиар тогтооно.</p>
10	<b>Хорват</b>	<p>119-р зүйл. <b>Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн Парламент томилж, чөлөөлнө.</b> Ингэхдээ Дээд шүүхийн ерөнхий хурал болон Парламентын эрх бүхий хорооны саналыг урьдчилан авсан байна. <b>Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг 4 жилийн хугацаагаар томилно.</b> Шүүхийг байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүнийг хуулиар тогтооно. 123-р зүйл. <b>Шүүгчийг бүх насаар нь томилно.</b> Шүүгчийн дараах тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Үүнд:  <ul style="list-style-type: none"> <li>- Өөрөө хүсэлт гаргасан,</li> <li>- Хөдөлмөрийн чадвараа бүр мөсөн алдсан,</li> <li>- Эрүүгийн гэмт хэрэг үйлдэж, шүүгчээр ажиллах шаардлагыг хангахаа больсон,</li> <li>- Сахилгын ноцтой зөрчил гаргаж Үндэсний шүүхийн зөвлөлөөс хуульд заасны дагуу шийдвэр гаргасан,</li> <li>- <b>70 нас хүрсэн.</b></li> </ul> 124-р зүйл. <b>Үндэсний шүүхийн зөвлөл</b> нь Үндсэн хууль болон хуульд заасны дагуу Дээд шүүхийн ерөнхий шүүгчээс <b>бусад шүүгч тэргүүлэгч шүүгчийг томилох, дэвшүүлэх, шилжүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг бие даан шийдвэрлэнэ.</b></p>
11	<b>Чех</b>	<p>62-р зүйл. БНУлсын <b>Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Шүүгч дотроос Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон дэд шүүгчийг томилно.</b> <b>63-р зүйл. БНУлсын Ерөнхийлөгч дараах эрхийг эдэлнэ.</b> <b>-Шүүгчийг томилох.</b> 93-р зүйл. 1. <b>Шүүгчийг хязгааргүй хугацаагаар</b> БНУлсын Ерөнхийлөгч томилно. 2. Ёс суртахууны шаардлага хангасан, хууль зүйн дээд боловсролтой иргэнийг шүүгчээр томилно. Шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлага, томилохтой холбоотой асуудлыг хуулиар тогтооно.</p>
12	<b>Швед</b>	<p>11-р хэсэг 1-р бүлэг. Дээд шүүхийн шүүгч, эсхүл Захиргааны хэргийн дээд шүүхийн гишүүнээр гагцхүү одоо, эсхүл урьд өмнө байнгын шүүгчээр томилогдож байсан шүүгчийг томилно. 3 бүлэг. 6-р зүйл. <b>Байнгын шүүгчийг /Permanent salaried judge/Засгийн газар томилно.</b> Томилгоог хийдээ чадвар, мерит зэрэг объектив чанарыг харгалзан үзнэ. Байнгын шүүгчийг томилох процедурыг хуулиар тогтооно. 7-р зүйл. Байнгын шүүгчийг зөвхөн дараах тохиолдолд чөлөөлнө. Үүнд: 1. Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл ажил үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлж тухайн албанд тохирохгүй болохыг нотолсон, 2. <b>тэтгэврийн насанд хүрсэн</b>, эсхүл хуульд заасны дагуу хөдөлмөрийн чадвараа алдсан бол. 8-р зүйл. Захиргааны хэргийн дээд шүүх Дээд шүүхийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, түдгэлзүүлэх, эсхүл эрүүл мэндийн үзлэгт орох шаардлагатай эсэхийг тогтооно. Дээрх заалт Захиргааны хэргийн дээд шүүхийн гишүүнд хамааралтай нөхцөлд Парламентын Омбудсмен, эсхүл Шударга ёсны канцлер / Chancellor of justice/ санаачилгыг гаргана. 10-р зүйл. Байнгын шүүгчийн эрх зүйн байдал болон бусад асуудлыг хуулиар тогтооно. 11-р зүйл. Байнгын шүүгчээр зөвхөн Шведийн иргэнийг томилно.</p>

13	<b>Швейцар</b>	143-р зүйл. <b>Санал өгөх</b> эрхтэй аливаа иргэн Үндэсний зөвлөл, Холбооны зөвлөл, эсхүл Холбооны дээд шүүхийн гишүүнээр сонгогдох эрхтэй байна. /18/ 145-р зүйл. Үндэсний зөвлөл болон Холбооны зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. <b>Холбооны дээд шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил</b> байна. 168-р зүйл. <b>Холбооны Ассамблей нь</b> Холбооны зөвлөлийн гишүүд, Холбооны Канцлер, <b>Холбооны Дээд шүүхийн шүүгч</b> , мөн дайны байдалд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийг сонгоно.
14	<b>Эстони</b>	147-р зүйл. <b>Шүүгчдийг бүх насаараа томилогдоно.</b> Шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлж, огцруулах үндэслэл, журмыг хуулиар тогтооно. Шүүгчийг гагцхүү шүүхийн шийдвэрээр огцруулна. Шүүгч нь хуульд зааснаас өөрөөр албан тушаалд томилогдох, сонгогдохыг хориглоно. Шүүгчийн эрх зүйн байдал, хараат бус байдлын баталгааг хуулиар тогтооно. 150-р зүйл. <b>Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Парламент</b> Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн томилно. <b>Дээд шүүхийн шүүгчдийг</b> Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн санал болгосноор <b>Парламент, бусад шүүхийн шүүгчийг</b> Дээд шүүхийн санал болгосноор <b>Ерөнхийлөгч тус тус томилно.</b>
15	<b>Япон</b>	6-р зүйл. Парламентаас нэрийг дэвшүүлсний дагуу <b>Эзэн хаан</b> Ерөнхий сайдыг, <b>Засгийн газрын өргөн мэдүүлснээр дээд шүүхийн ерөнхий шүүгчийг</b> тус тус томилно. 79-р зүйл. Дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон хуульд заасан тооны бусад шүүгчээс бүрдэх бөгөөд <b>Ерөнхий шүүгчээс бусад шүүгч нарыг Засгийг газар</b> томилно. Дээд шүүхийн шүүгчдийн талаар томилогдсоноос нь хойш болсон анхны Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн сонгуулийн үеэр ард иргэдийн хэлэлцүүлэг явуулах ба арван /10/ жилийн хугацаа өнгөрөхөд мөн Төлөөлөгчдийн танхимын сонгогчдын гишүүдийн ерөнхий сонгуулийн дараа дахин хэлэлцүүлэг явуулах ба энэ ажиллагааг 10 жил тутам давтан явуулна. Гишүүдийн дийлэнхийн саналаар шүүгчийг огцруулна. 80-р зүйл. <b>Доод шатны шүүхийн шүүгчийг Дээд шүүхээс санал болгосон нэрсийн жагсаалтаас Засгийн газар томилно.</b> Дээрх шүүгчдийг <b>10 жилийн</b> хугацаагаар томилох ба улируулан томилж болно. Ингэхдээ <b>хуульд заасан насны хязгаар</b> хүрэхдээ тэтгэвэрт гарна.

**Гурав. Үндсэн хуульд шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаар**

Улсын нэр		Томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалт			
		Ерөнхийлөгч	Парламент	Засгийн газар	Бусад / Шүүгчид
1	<b>Израиль</b>	-	-Кнессетээс сонгосон Кнессетийн 2 гишүүн	-Хууль зүйн сайд -Засгийн газраас томилсон сайд нийт 2 гишүүнийг	-Дээд шүүхийн ерөнхийлөгч (ерөнхий шүүгч) -1 -бие даасан шүүхийн байгууллагаас сонгогдсон дээд шүүхийн 2 шүүгч -2 -Танхимын Үндэсний Зөвлөлөөс сонгосон Өмгөөлөгчдийн Танхимын 2 төлөөлөгч -2 Нийт -5 гишүүн

2	<b>Испани</b>	Эзэн хаан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг 5 жилийн хугацаатай томилно.	-	-	-
3	<b>Итали</b>	Зөвлөлийг Улсын Ерөнхийлөгч тэргүүлнэ.	1/3-ийг хуульчид, профессоруудын дундаас Парламент хамтарсан хуралдаанаараа сонгоно.	-	Гишүүдийн 2/3-ыг бүх шүүгчид сонгоно.  Давж заалдах шатны шүүхийн анхны ерөнхий шүүгч болон ерөнхий прокурор гишүүний эрхтэй байна.
4	<b>Киргиз</b>		-Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийн 1/3-ийг Парламентын олонх, 1/3-ийг Парламентын сөрөг хүчин тус тус сонгоно. -Парламент Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батална.		<b>Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийн 1/3-ийг Шүүгчдийн зөвлөл сонгоно.</b>
5	<b>Нидерланд</b>	-	-	-	-
6	<b>Словак</b>	3 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.	3 гишүүнийг Парламент томилж, чөлөөлнө.	3 гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө.	Шүүхийн зөвлөлийн даргыг шүүхийн зөвлөлийн гишүүд өөрсдийн гишүүд дундаас томилж, чөлөөлнө. 9 гишүүнийг шүүгчид томилж, чөлөөлнө
7	<b>Словени</b>	-	5 гишүүнийг хууль зүйн сургуулийн профессор, өмгөөлөгч болон бусад хуульчид дундаас Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент	-	Гишүүд өөрсдийн бүрэлдэхүүн дотроос зөвлөлийн даргыг сонгоно. Бүх насаар шүүгчээр томилогдсон шүүгчид өөрсдийн бүрэлдэхүүн дотроос 6 гишүүнийг томилно.
8	<b>Унгар</b>	-	Ерөнхийлөгчийн санал болгосноор Үндэсний шүүхийн зөвлөлийн даргыг томилно.	-	-
9	<b>Финланд</b>	-	-	-	-

10	<b>Хорват</b>	-	-	-	Үндэсний шүүхийн зөвлөлийн даргыг гишүүдийнх нь дотроос Даргыг сонгоно. Үндэсний шүүхийн зөвлөл нь бусад шүүгч тэргүүлэгч шүүгчийг томилох, дэвшүүлэх, шилжүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг бие даан шийдвэрлэнэ.
11	<b>Чех</b>	-	-	-	-
12	<b>Швед</b>	-	-	-	-
13	<b>Швейцар</b>	-	-	-	-
14	<b>Эстони</b>	-	-	-	-
15	<b>Япон</b>	-	-	-	-

Улсын нэр		Үндсэн хуульд шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаар		
		Гишүүдийн тоо		Бүрэн эрхийн хугацаа
1	<b>Израиль</b>	4 дүгээр зүйл 9 гишүүн: -1 гишүүн нь Дээд шүүхийн Ерөнхийлөгч, -2 гишүүн нь бие даасан шүүхийн байгууллагаас сонгогдсон Дээд шүүхийн шүүгч, -2 гишүүн нь Хууль зүйн яамны сайд болон Засгийн газраас томилсон сайд, -2 гишүүн нь Кнессет (парламент)-ээс сонгосон Кнессетийн хоёр гишүүн, -2 гишүүн нь Өмгөөлөгчдийн танхимын хоёр төлөөлөгчөөс байна.		-
2	<b>Испани</b>	Шүүхийн ерөнхий зөвлөл нь түүнийг даргалах Дээд шүүхийн Ерөнхийлөгч болон 20 гишүүний бүрэлдэхүүнтэй.		5 жил
3	<b>Итали</b>	I ХЭСЭГ. ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 104 дугаар зүйл Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөлийг (The High Council of the Judiciary) Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч тэргүүлнэ.  Кассацийн шүүх (давж заалдах шатны шүүх)-ийн анхны ерөнхийлөгч (ерөнхий шүүгч) болон ерөнхий прокурор гишүүний эрхтэй байна.  Гишүүдийн гуравны хоёрыг бүх төрлийн шүүхэд харъяалагдах бүх шүүгчид сонгох ба гуравны нэгийг хуулийн сургуулийн профессорууд болон 15 жилийн ажлын туршлагатай хуульчдын дундаас Парламент хамтарсан хуралдаанаараа сонгоно.  Зөвлөл Парламентаас томилсон гишүүд дундаас дэд ерөнхийлөгчөө сонгоно.		-4 жил бүрэн эрхийн хугацаа дуусмагц улируулан сонгохгүй
4	<b>Киргиз</b>	-		-
5	<b>Нидерланд</b>	-		-

6	<b>Словак</b>	18 гишүүн	-
7	<b>Словени</b>	11 гишүүн	
8	<b>Унгар</b>		9 жил
9	<b>Финланд</b>	-	-
10	<b>Хорват</b>	11 гишүүн 7 гишүүн нь шүүгч, 2 гишүүн нь хууль зүйн сургуулийн профессор, 2 гишүүн нь Парламентын гишүүн	4 жил
11	<b>Чех</b>	-	-
12	<b>Швед</b>	-	-
13	<b>Швейцар</b>	-	-
14	<b>Эстони</b>	-	-
15	<b>Япон</b>	-	-

Улсын нэр		Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх	
1	<b>Израиль</b>	<p style="text-align: center;"><b>4 дүгээр зүйл</b></p> <p>b. Шүүхийн сонгуулийн хороо нь дараах 9 гишүүнээс бүрдэнэ:  -Дээд шүүхийн Ерөнхийлөгч,  -бие даасан шүүхийн байгууллагаас сонгогдсон Дээд шүүхийн хоёр шүүгч,  -Хууль зүйн яамны сайд болон Засгийн газраас томилсон сайд,  -Кнессет (парламент)-ээс сонгосон Кнессетийн хоёр гишүүн,  -Танхимын Үндэсний Зөвлөлөөс сонгосон Өмгөөлөгчдийн танхимын хоёр төлөөлөгчөөс бүрдэнэ.</p> <p>c. Хорооны гишүүдийн тоог багасгасан ч долоогоос доош гишүүнтэй байж болохгүй.</p>	
2	<b>Испани</b>	<p><b>122-р хэсэг.</b>  2.Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн удирдах байгууллага байна. Түүний эрх зүйн байдал, болон гишүүдийн чиг үүрэг, томилгоо, тушаал дэвших, байцаан шалгалт, сахилгын асуудаар гишүүдэд үл нийцэх тогтолцоог органик хуулиар тогтооно.  3.Шүүхийн ерөнхий зөвлөлийг даргалах Дээд шүүхийн Ерөнхийлөгч, түүний 20 гишүүнийг Эзэн хаан 5 жилийн хугацаатай томилно. Гишүүдийн 12-ийг бүх төрлийн шүүхийн шүүгч, магистратаас томилно; 4-ийг Конгрессоос, 4-ийг Сенатаас тус тус гишүүдийн 3/5-ийн саналаар санал болгоно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.</p>	



3	Итали	<p style="text-align: center;"><b>104 дугаар зүйл</b></p> <p>Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөлийг (The High Council of the Judiciary) Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч тэргүүлнэ.</p> <p>Кассацийн шүүх (давж заалдах шатны шүүх)-ийн анхны ерөнхийлөгч (ерөнхий шүүгч) болон ерөнхий прокурор гишүүний эрхтэй байна.</p> <p>Гишүүдийн гуравны хоёрыг бүх төрлийн шүүхэд харъяалагдах бүх шүүгчид сонгох ба гуравны нэгийг хуулийн сургуулийн профессорууд болон 15 жилийн ажлын туршлагатай хуульчдын дундаас Парламент хамтарсан хуралдаанаараа сонгоно.</p> <p>Зөвлөл Парламентаас томилсон гишүүд дундаас дэд ерөнхийлөгчөө сонгоно.</p> <p>Зөвлөлд сонгогдсон гишүүдийн албаны бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх ба бүрэн эрхийн хугацаа дуусмагц улируулан сонгохгүй.</p> <p style="text-align: center;"><b>105 дугаар зүйл</b></p> <p>Шүүх эрх мэдлийн Дээд Зөвлөл нь шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажил эрхлэлт, шүүгчийг албан тушаалд томилох болон шилжүүлэх, шүүгчийн урамшуулал болон шүүгчид сахилгын арга хэмжээ авах зэрэг хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p>
4	Киргиз	<p><b>64-р зүйл.</b> 4.Парламент /Жогорку Кенеш/: 2) хуульд заасны дагуу Шүүгчдийн сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батална;</p> <p><b>95-р зүйл.</b> 4.Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөл нь орон нутгийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг сонгох болон томилсон, эсхүл шилжүүлсэн талаар мэдэгдэх үүргийг үндсэн хуулийн хуулиар тогтоосон журмын дагуу хэрэгжүүлнэ. 7.Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөл нь шүүгчид болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэнэ. Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийн гуравны нэгийг Шүүгчдийн зөвлөл, гуравны нэгийг Парламентын олонх, гуравны нэгийг Парламентын сөрөг хүчин тус тус сонгоно. 8.Шүүгчдийг сонгон шалгаруулах зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаа, бүрэн эрх, бүрдүүлэх журмыг хуулиар тогтооно.</p> <p><b>102-р зүйл.</b> 1.Шүүхийн бие засгийн газар үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоцны дотоод үйл ажиллагааны асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй. 2.БНКУ-ын шүүхийн өөрөө удирдах байгууллага нь Шүүгчдийн их хурал, Шүүхийн зөвлөл болон Шүүгчдийн хурал байна. Шүүгчдийн их хурал нь шүүхийн өөрөө удирдах дээд байгууллага байна. Шүүхийн зөвлөл нь шүүхийн өөрөө удирдах сонгуульт байгууллага бөгөөд Шүүгчдийн их хурлын завсарлагын хугацаанд үйл ажиллагаа явуулах, шүүгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн төсвийн төслийг боловсруулах болон төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, шүүгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, шүүгчдийг сахилгын хариуцлагад татах асуудлыг авч үзэх үүрэгтэй. Шүүгчдийн хурал нь шүүхийн өөрөө удирдах анхан шатны байгууллага байна. 3.Шүүхийн өөрөө удирдах байгууллагын бүтэц, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.</p>
5	Нидерланд	-



6	<b>Словак</b>	<p>141а-р зүйл.  1. Шүүхийн зөвлөлийн даргыг Шүүхийн зөвлөлийн гишүүдийнх нь дотроос сонгож, чөлөөлнө.  <b>БНСловак Улсын Шүүхийн зөвлөл нь дараах гишүүдээс бүрдэнэ:</b>  А. 9 гишүүнийг шүүгчид өөрсдийн бүрэлдэхүүнээ томилж, чөлөөлнө.  Б. 3 гишүүнийг Үндэсний зөвлөл /Парламент/ томилж, чөлөөлнө.  В. 3 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.  Г. 3 гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө.  2. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээр <b>15-аас доошгүй жил ажилласан</b> этгээд нь Шүүхийн зөвлөлийн дарга, эсхүл 141а б-г заалтад дурдсан гишүүнээр сонгогдох эрхтэй байна.  4. шүүхийн зөвлөлийн гишүүнийг <b>5 жилийн хугацаагаар томилох</b> ба Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь гишүүнээр 2 дараалсан бүрэн эрхийн хугацаанаас дээшгүй томилогдох, сонгогдох эрхтэй байна.</p>
7	<b>Словени</b>	<p><b>130-р зүйл. Шүүгч нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Парламент сонгоно.</b>  <b>131-р зүйл. Шүүхийн зөвлөл нь 11 гишүүнтэй байна.</b> 5 гишүүнийг хууль зүйн сургуулийн профессор, өмгөөлөгч болон бусад хуульчид дундаас Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент, бүх насаар шүүгчээр томилогдсон шүүгчид өөрсдийн бүрэлдэхүүн дотроос 6 гишүүнийг тус тус сонгоно. Гишүүд өөрсдийн бүрэлдэхүүн дотроос зөвлөлийн даргыг сонгоно.  132-р зүйл. Шүүгч нь Үндсэн хууль, эсхүл бусад хуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд Парламентын Шүүхийн зөвлөлийн санал болгосноор огцруулна.</p>
8	<b>Унгар</b>	<p>Парламент  1-р зүйл.  2. Парламент нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  БНУлсын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүхийн гишүүд болон дарга, Дээд шүүх /Куриа/-ийн дарга, Үндэсний шүүхийн зөвлөлийн дарга, Ерөнхий прокурор, Үндсэн эрхийн комиссар болон орлогчдыг, Төрийн аудитын албаны даргыг тус тус томилно.  Ерөнхийлөгч  9-р зүйл.  Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  j. Ерөнхий сайд, Куриягийн Ерөнхийлөгч, <b>Унгарын Үндэсний шүүхийн зөвлөлийн дарга</b>, Ерөнхий прокурор, Үндсэн эрхийн комиссарыг <b>томилох нэр дэвшигчийг санал</b> болгоно.  25-р зүйл.  б. <b>Унгарын Үндэсний шүүхийн зөвлөлийн даргыг Парламент Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн шүүгчид дундаас 9 жилийн хугацаагаар томилно.</b>  <b>Үндэсний шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг</b> Парламентын гишүүдийн гуравны хоёр /дийлэнх олонх/-ын саналаар томилно. Дээд шүүх /Curia/-ийн даргыг Үндэсний шүүхийн зөвлөлийн гишүүн байх ба хуульд заасны дагуу шүүгчид сонгоно.  8. шүүхийн зохион байгуулалт, удирдлагын нарийвчилсан журам, шүүгчдийн эрх зүйн байдал, шүүгчдийн цалин хөлсийг хуулиар тогтооно.  26-р зүйл.  2. Мэргэжлийн шүүгчийг хуульд заасны дагуу Ерөнхийлөгч томилно. Шүүгчээр зөвхөн 30 нас хүрсэн иргэнийг томилно. Дээд шүүх /Curia/-ийн дарга болон <b>Үндэсний шүүхийн зөвлөлийн даргаас бусад шүүгчийн бүрэн эрх тэтгэврийн нас хүрснээр дуусгавар болно.</b></p>
9	<b>Финланд</b>	-

10	<b>Хорват</b>	<p>124-р зүйл. <b>Үндэсний шүүхийн зөвлөл</b> нь Үндсэн хууль болон хуульд заасны дагуу Дээд шүүхийн ерөнхий шүүгчээс <b>бусад шүүгч тэргүүлэгч шүүгчийг томилох, дэвшүүлэх, шилжүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг бие даан шийдвэрлэнэ.</b></p> <p>Үндэсний шүүхийн зөвлөл нь <b>11 гишүүнээс</b> бүрдэх ба 7 гишүүн нь шүүгч, 2 гишүүн нь хууль зүйн сургуулийн профессор, 2 гишүүн нь Парламентын гишүүн байх ба нэг нь сөрөг хүчний намаас байна.</p> <p><b>Үндэсний шүүхийн зөвлөлийн даргыг гишүүдийнх нь дотроос Даргыг сонгоно.</b></p> <p>Шүүхийн даргыг Үндэсний шүүхийн зөвлөлд сонгохыг хориглоно.</p> <p>Үндэсний шүүхийн зөвлөлийн гишүүдийг <b>4 жилийн</b> хугацаагаар томилно.</p> <p>Үндэсний шүүхийн зөвлөлийн гишүүдийг улируулан томилохыг хориглоно.</p> <p>Үндэсний шүүхийн зөвлөлийн эрх үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон сонгон шалгаруулах зарчмыг хуулиар тогтооно.</p>
11	<b>Чех</b>	-
12	<b>Швед</b>	-
13	<b>Швейцар</b>	-
14	<b>Эстони</b>	-
15	<b>Япон</b>	-

**Дөрөв. Үндсэн хууль дахь ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг бүрдүүлэх асуудлаар**

№	Улс	Ерөнхий сайдыг томилох зохицуулалт	Засгийн газрыг бүрдүүлэх, огцруулах зохицуулалт
1.	<b>Бельги</b>	<p>96-р зүйл. Хаан [өөрийнхөө] сайд нарыг томилж, чөлөөлнө. Төлөөлөгчдийн танхим Засгийн газарт итгэхгүй байгаагаа зохих журмаар илэрхийлсэн тохиолдолд Холбооны засгийн газар Хаанд огцрох тухай хүсэлт тавина. Төлөөлөгчдийн танхим Ерөнхий сайдаар томилуулах хүнийг хаанд санал болгоно. Хааны томилсон Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Холбооны Засгийн газар тангараг өргөсөн тохиолдолд албан үүргээ гүйцэтгэдэг.</p> <p>101, 104. Сайд нар Төлөөлөгчийн танхимын өмнө ажлаа хариуцна. Төрийн нарийн бичгийн дарга нарыг Хаан томилно.</p>	
2.	<b>Дани</b>	<p>14-р зүйл. Хаан Ерөнхий сайд болон бусад сайдуудыг томилж, чөлөөлнө. Тэрээр сайд нарын тоо, тэдгээрийн хоорондын харилцаа, засгийн газрын үүргийг хуваарилах эрхтэй.</p> <p>Мөн Хаан хууль тогтоомжтой холбоотой тогтоол болон засгийн газрын тогтоолыг хүчин төгөлдөр болгоход батламжлан гарын үсэг зурах ба Хааны гарын үсгийн хамт нэг болон түүнээс дээш сайд гарын үсэг зурна.</p> <p>Тогтоолыг баталсан сайд тогтоолыг хариуцдаг.</p>	<p>12. Энэхүү Үндсэн хуульд заасан хязгаарлалтын дагуу Хаан нь Хаант улсын бүхий л хэрэгт дээд эрх мэдлийг эдлэх бөгөөд түүнийг сайд нараар дамжуулан хэрэгжүүлнэ.</p> <p>13. Хаан өөрийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй. Түүний нэр төр цэвэр байх ёстой. Сайд нар Засгийн газрын үйл ажиллагааг хариуцан явуулах ба тэдгээрийн хариуцлагыг хуулиар тогтооно.</p>

3.	<b>Норвег</b>	<p>Ерөнхий сайд болон бусад сайд нарыг хуулиар томилж, чөлөөлнө.</p>	<p>3-р зүйл. Гүйцэтгэх эрх мэдлийг Хаан, эсхүл энэ хуулийн 6 дугаар зүйл, 7, эсхүл 48 дугаар зүйлд заасны дагуу Хаан ширээнд заларсан Хатан хаан хэрэгжүүлнэ.</p> <p>12-р зүйл. Хаан өөрөө санал өгөх эрх бүхий Норвеги Улсын иргэд дундаас Зөвлөлийг сонгоно. Энэхүү Төрийн зөвлөл нь Ерөнхий сайд болон долоогоос доошгүй гишүүнээс бүрдэнэ. Хаан нь Төрийн Зөвлөлийн гишүүдэд өөрийн зохимжоор ажил үүргийг хуваарилна. Онцгой тохиолдолд Хаан нь Төрийн Зөвлөлийн энгийн гишүүдээс гадна Стортингийн гишүүд бус Норвегийн иргэнийг Төрийн Зөвлөлийн гишүүнээр томилж болно.</p>
4	<b>Нидерланд</b>	<p>43-р зүйл. Ерөнхий сайд болон бусад сайд нарыг Хааны зарлигаар томилж, чөлөөлнө.</p> <p>45-р зүйл.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сайд нар Засгийн газрыг бүрдүүлнэ.</li> <li>2. Ерөнхий сайд Засгийн газрыг тэргүүлнэ.</li> <li>3. Засгийн газрын бүрэлдэхүүн нь Засгийн газрын ерөнхий бодлогыг тодорхойлж, уялдаа холбоог хангаж ажиллана.</li> </ol>	<p>42-р зүйл</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газар нь Хаан болон сайд нараас бүрдэнэ.</li> <li>2. Засгийн газрын үйл ажиллагаанд Хаан бус, сайд нар хариуцлага хүлээнэ.</li> </ol> <p>44-р зүйл.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Яамдыг Хааны зарлигаар байгуулна. Тэдгээрийг сайд тэргүүлнэ.</li> <li>2. Яамгүй сайд нарыг томилж болно.</li> </ol>
5	<b>Швед</b>	<p>6.3.4 Засгийн газрыг бүрдүүлэх</p> <p>Ерөнхий сайдыг томилохын өмнө спикер нь парламентад суудал бүхий намуудтай зөвшилцөх бөгөөд Риксдагт Ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулахын өмнө мөн дэд даргатай зөвшилцсөн байна. Нэр дэвшигчийг танилцуулснаас хойш 4 хоногийн дотор нийт гишүүдийн олонхын саналаар томилно. Хэрэв Риксдагийн гишүүдийн талаас илүү хувь нь эсрэг санал өгсөн бол түүнийг татгалзана. Бусад тохиолдолд энэ нь батлагддаг.</p> <p>5-р зүйл. Риксдаг нь спикерийн саналыг / нэр дэвшүүлсэн хүнийг/ дэмжээгүй тохиолдолд 4-р зүйлд заасан журмыг давтана.</p> <p>Хэрэв Риксдаг спикерийн саналыг 4 удаа дэмжээгүй бол Ерөнхий сайдыг томилох асуудлыг, зөвхөн Риксдагийн сонгууль явагдсаны дараа хэлэлцэнэ.</p> <p>Хэрэв 3 сарын дотор ээлжит сонгууль явагдхааргүй бол, онцгой буюу ээлжит бус сонгуулийг дээрхтэй адил хугацаанд явуулна.</p>	<p>6-р зүйл. Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Риксдаг баталсны дараа Ерөнхий сайд нь сайд нарын нэрсийг аль болох богино хугацаанд Риксдагт мэдэгдэнэ. Үүний дараагаар Төрийн тэргүүн, эсхүл түүний эзгүйд Спикерийн өмнө шинэ Засгийн газар ажлаа хүлээж авна. Спикерийг энэхүү зөвлөлд хүрэлцэн ирэхийг дуудна. Спикер нь Риксдагийн нэрийг өмнөөс Ерөнхий сайдыг томилсон тогтоол гаргана.</p> <p>7-р зүйл. Риксдаг нь Ерөнхий сайд, эсхүл түүний Засгийн газрын гишүүн нь Риксдагт итгэл үзүүлэх боломжгүй гэж зарласан тохиолдолд Спикер нь тухайн сайдыг огцруулна. Ингэхдээ Засгийн газар нь Риксдагийн ээлжит бус сонгууль зарлах эрхтэй байх ба итгэл үл үзүүлэх тухай мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд Сайдыг огцруулахгүй. Сонгууль явагдсаны дараа Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаар Ерөнхий сайдыг огцруулах журмыг 3-р зүйлд заасан.</p> <p>8-р зүйл. Ерөнхий сайд нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж болох ба Ерөнхий сайдыг Спикер, бусад сайд нарыг Ерөнхий сайд чөлөөлнө. Ерөнхий сайд нь бусад шалтгаанаар сайд нарыг огцруулж болно.</p> <p>9-р зүйл. Ерөнхий сайд чөлөөлөгдсөн, эсхүл нас барсан тохиолдолд бусад сайд нарыг Спикер чөлөөлнө.</p>

6	Япон	<p>67-р зүйл. Ерөнхий сайдыг Парламентын гишүүд дотроос Парламентын шийдвэрээр батална. Энэхүү ажиллагааг бусад ажил үүргээс нэн тэргүүнд гүйцэтгэнэ. Төлөөлөгчдийн танхим ба Зөвлөхүүдийн танхим санал зөрөлдсөн, эсхүл хоёр танхимын хамтарсан байнгын хорооноос шийдвэр гараагүй, хуульд заасны дагуу Төлөөлөгчдийн танхим нэр дэвшүүлснээс хойш Парламентыг завсарлагыг үл тооцоод 10 хоногийн дотор Зөвлөхүүдийн танхим тухайн нэр дэвшигчийн талаар шийдвэр гаргаагүй тохиолдолд Төлөөлөгчдийн танхимын шийдвэр нь Парламентын шийдвэр байна.</p> <p>68-р зүйл. Ерөнхий сайд нь төрийн сайд нарыг томилно. Гэхдээ тэдгээрийн олонхийг Парламентын гишүүд дундаас сонгон томилно.</p>	<p>68-р зүйл. Ерөнхий сайд нь төрийн сайд нарыг томилно. Гэхдээ тэдгээрийн олонхийг Парламентын гишүүд дундаас сонгон томилно.</p> <p>Ерөнхий сайд нь өөрийн үзэмжээр төрийн сайд нарыг албан тушаалаас нь огцруулж болно.</p> <p>69-р зүйл.Төлөөлөгчдийн танхим нь Засгийн газарт итгэл үл үзүүлэх тухай шийдвэр гаргасан, эсхүл итгэл үзүүлэх шийдвэрээс татгалзсан бол Төлөөлөгчдийн танхим 10 хоногийн дотор тараагүй бол Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно.</p> <p>70-р зүйл.Ерөнхий сайдын албан тушаал эзэнгүй болсон, эсхүл Төлөөлөгчдийн танхимын ерөнхий сонгуулийн дараа Парламентын анхны чуулганыг зарласан бол Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно.</p>
---	------	--	---